

**ОРОН СУУЦ НИЙТИЙН АЖ АХУЙН УДИРДАХ
ГАЗАР ОНӨААТҮГ**

**Баруун бүсийн орон сууцны байруудын цахилгааны ерөнхий щит
шинэчилэн солих ажлын тендерийн бичиг баримт**

Тендер шалгаруулалт: ***Баруун бүсийн орон сууцны байруудын
цахилгааны ерөнхий щит шинэчилэн солих ажил***

Гэрээний нэр дугаар: **ОСНААУГ-ЗА-20/07**

**Улаанбаатар хот
2020**

Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2020-05-25

Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос **Баруун бүсийн байруудын цахилгааны ерөнхий щит шинэчилэн солих ажлыг** гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2020 оны 06 дугаар сарын 02-ний 10 цаг 30** минутаас өмнө www.tender.gov.mn цахим хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2020 оны 06 дугаар сарын 30-ний өдрийн 11цаг 00 минутад** нээнэ.

Дотоодны давуу эрх тооцох эсэх: **тооцохгүй**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо, Бумцэндийн гудамж, Их тойруу, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар 3 давхар 301 тоот

Утас-70111742

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч**

1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**

2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.

2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.

2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**

3.1. Тендерт оролцогчдод өгсөн зааварчилгааны дагуу бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ:

 - (а) Үнийн санал;
 - (б) Үнэлэгдсэн үе шатны ажлын хуваарь;
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тендерийн үнэ**

4.1. Тендерийн үнэд тодорхойлсон нийт ажил хамрах ба тендерт оролцогчийн үнэлж ирүүлсэн үе шатны ажлын хуваарьт үндэслэнэ.

4.2. Тендерт оролцогч үнийн хөнгөлөлтийг тендерт тусган санал болгож болно.

4.3. Тендерт оролцогч нь зураг болон техникийн тодорхойлолтод тодорхойлогдсон ажлыг үнэлэхдээ үе шатны ажлын хуваарьт хураангуй байдлаар өгөгдсөн бүх нэр төрөлд нэгж үнэ болон нийт үнэ санал болгоно. Тендерт оролцогч аль нэг нэр төрлийн нэгж үнэ болон нийт үнийг бөглөөгүй орхисон тохиолдолд түүнийг гүйцэтгэсний төлбөрийг захиалагч хийхгүй ба бусад нэр төрлийн үнэд багтсан гэж үзнэ.

4.4. Тендерт оролцогч нь тендер хүлээн авах эцсийн хугацаанаас 14 хоногийн өмнө хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хууль тогтоомжийн дагуу энэ гэрээ болон бусад үндэслэлээр гүйцэтгэгчийн төлөх ёстой бүх татвар, хураамж, бусад төлбөрийг тендерийн нийт үнэд багтаасан байна.
- 5. Үнийн саналын**

5.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.

**хүчинтэй
байх хугацаа**

- 6. Алдааг залруулах**
- 6.1. Захиалагч шаардлагад нийцсэн тендерийн арифметик алдааг шалгаж дараах байдлаар залруулна:
- (а) тоо болон үсгээр илэрхийлэгдсэн дүн хоорондоо зөрсөн бол үсгээр илэрхийлэгдсэнийг зөв гэж үзнэ;
 - (б) үе шатны ажлын үнийн нийлбэр тендерийн маягтад заасан тендерийн нийт үнээс зөрвөл үе шатны ажлын үнийн нийлбэрийг үндэслэн тендерийн нийт үнийг залруулна;
 - (в) нэгж үнийг ажлын тоо хэмжээгээр үржүүлж гаргасан нэг мөр дэх нийт дүнд зөрүү гарвал нэгж үнийг давамгайлах гэж үзнэ. Гэхдээ захиалагчийн үзэж байгаагаар нэгж үнэд аравтын орны таслалыг андуурсан болох нь илэрхий байвал тухайн мөр дэх нийт дүнг зөв гэж үзэн холбогдох нэгж үнийг залруулна.
- 6.2. Захиалагчийн залруулсан тендерийн дүнг тендерт оролцогчийн зөвшөөрлөөр эцсийнх гэж үзнэ. Хэрэв тендерт оролцогч залруулсан дүнг хүлээн зөвшөөрөхгүй бол захиалагч түүний тендерээс татгалзана.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдийн үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө утсан холбоогоор мэдэгдэж, албан бичгээр баталгаажуулна. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

ТӨӨЗ-ны холбогдох заалт	Шалгуур үзүүлэлт
ТӨӨЗ 1.1	<ol style="list-style-type: none"> 1. Үнийн саналыг маягтын дагуу бэлтгэж, баталгаажуулан ирүүлнэ. 2. Ажлын зураг, тоо хэмжээний дагуу тооцсон ажлын төсөвийг “stimator.pro” програмаар /Мэргэжлийн төсөвчнөөр хийлгэж, тамга тэмдгээр баталгаажуулсан байх 3. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбарыг ирүүлнэ. 4. НӨАТ төлөгч байх ба гэрчилгээний хуулбар ирүүлэх 5. Тусгай зөвшөөрөл: 6. Барилга, хот байгуулалтын яамны: <ol style="list-style-type: none"> 2.2.2. Барилгын дотор гэрэлтүүлэг, цахилгаан хангамжийн угсралт, тухайн барилгын гадна салбар шугам сүлжээний угсралт Эрдэс баялаг Эрчим хүчний яамны: <ol style="list-style-type: none"> 03.2.1 0.4-10кВ-ын ЦДШ, дэд станцын засвар, угсралт, түүний туршилт, тохируулга, дагалдах ажил үйлчилгээ эрхлэх холбогдох тусгай зөвшөөрлүүдийн аль нэг нь байж болно. 7. Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: Сүүлийн 2 жил буюу 2018, 2019 онуудын аль нэг жилд нь доод тал нь нэг удаа ижил төстэй ажил гүйцэтгэх гэрээний үндсэн гүйцэтгэгчээр ажилласан байна. Гүйцэтгэсэн ижил төстэй ажлуудын талаар доорх нотлох баримтуудыг ирүүлнэ. 8. Үүнд: 9. Ажил гүйцэтгэсэн гэрээний хуулбар 10. Ажил хүлээлцсэн акт болон протоколын хуулбар 11. Сүүлийн нэг /2019 он/ жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан, дүгнэлтийн хамт ирүүлэх 12. Татварын тодорхойлолт ирүүлэх. /Монгол Улсын хуулийн дагуу татвар, хураамж, төлбөрөө тухайн тендер нээсэн өдрийн байдлаар бүрэн төлсөн байна. Татварын тодорхойлолтыг Татварын ерөнхий газрын сайтаас авч ирүүлэх ба энэхүү тодорхойлолт нь тендер нээсэн өдрийн байдлаар хүчинтэй байна. Мөн татварын байгууллагаас тодорхойлолт хүсэхэд татгалзах зүйлгүй тухай болон тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу татвар төлөлт, Сангийн яамны санхүүгийн тайлангийн сангаас санхүүгийн тайлангийн талаарх шаардлагатай мэдээллийг тендер нээсэн өдрийн байдлаар шалгахад татгалзах зүйлгүй тухай мэдэгдлийг албан бичгээр ирүүлнэ. 13. “Хугацаа хэтэрсэн зээл болон зээлийн хүүгийн төлбөрийн үлдэгдэлгүй” тухай харилцагч бүх банкны тодорхойлолтыг эх хувиар ирүүлнэ. 14. Ажлын даалгавар, шаардлагын дагуу санал болгосон үнээрээ, хугацаандаа чанартай хийж гүйцэтгэхийг баталсан албан бичиг ирүүлнэ. 15. Нийслэлийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх газрын

	<p>тодорхойлолт</p> <p>16. Шүүхийн ерөнхий зөвлөл шүүхийн төрөлжсөн архивын тодорхойлолт</p> <p>17. Нийгмийн даатгалын тодорхойлолт / тендерийн нээлт хийхээс өмнөх 3 сарын нийгмийн даатгалын тайлан /маягт НД 7,8/-аар</p> <p>18. Инженер техникийн ажилтнуудын ажлын туршлага танилцуулга, мэргэжлийн дипломны хуулбар ирүүлэх /Удирдах инженер -1, цахилгаан хангамжийн инженер-1 , хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн инженер-1, /</p> <p>19. Захиалагчийн төлөөлөгчтэй хамт орон сууцны байруудын цахилгааны ерөнхий шитний байршил, хүчин чадал, ачаалалтай танилцаж фото зургаар баталгаажуулах мөн шинээр угсрах шитний цахилгааны бүдүүвч схем гарган захиалагчтай зөвшилцсөн байх.</p> <p>20. Ажил гүйцэтгэх нарийвчилсан хугацааны графикыг баталгаажуулан ирүүлнэ</p> <p>21. Тоноглол, материал нэг бүрийн техникийн үзүүлэлтийг техникийн тодорхойлолтод шаардсан үзүүлэлттэй харьцуулан ирүүлэх</p> <p>22. Ажилд шаардагдах тоноглолын чанарын сертификатын хуулбар монгол орчуулгатай /баталгаажсан байх/</p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо, Бумцэндийн гудамж, Их тойруу, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар</i></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <i>Өөрийн байр 3 давхар 301 тоот</i></p> <p>Огноо: <i>2020 оны 06 дугаар сарын 02-ны өдөр</i></p> <p>Цаг: <i>10 цаг 30 минут</i></p>
ТӨӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: <i>Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 6 дугаар хороо, Бумцэндийн гудамж, Их тойруу, Орон сууц нийтийн аж ахуйн удирдах газар</i></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <i>Өөрийн байр 3 давхар 301 тоот</i></p> <p>Огноо: <i>2020 оны 06 дугаар сарын 02 өдөр</i></p> <p>Цаг: <i>11 цаг 00 минут</i></p>
ТӨӨЗ 6.2	<p>Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <i>багцгүй</i></p>

Дөрөв. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

Цахилгааны ерөнхий шит шинэчлэхэд тавигдах ерөнхий шаардлагууд

1. Цахилгаан байгууламжид мөрдөх аюулгүй ажиллагааны дүрэм, техник ашиглалтын дүрэм, цахилгаан байгууламжийн дүрмий шаардлагуудыг хангасан тоноглолууд байна.
2. Цахилгааны ерөнхий шитүүдэд туршилт, хэмжилтүүд заавал хийгдсэн байх ёстой.
3. Цахилгааны ерөнхий шитний хаалганы дотор талд шитний цахилгааны бүдүүвч зураг байна.
4. Гүйдэл дамжуулах шиний задаргааны уулзварыг боолтоор боож холбох
5. Шитний доод хэсэгт гаргалгаа шугамуудын “0” утас залгахад зориулсан тусдаа шин тоноглох
6. Шинийн суурийн эд анги болон тоноглолуудыг холбож газардуулах тусгай шин тоноглох
7. Шитний хаалганы гадна талд аюулгүй ажиллагааны анхааруулах тэмдэг, тэмдэглэгээ хийсэн байх
8. Гүйдэл дамжуулах шинийн залгалт хийгдээгүй гадаргууг зүүн гар / дээд талаас А фаз шар, дунд тал В фаз ногоон, баруун гар/ доод тал С фаз улаан өнгөтэй халалтад тэсвэртэй тусгаарлагч материалаар бүрсэн байх
9. Орон сууцны байруудын цахилгааны шит байрлах өрөөний онцлогт тохирсон бэхэлгээг шитний хайрцагуудад хийсэн байх.

Ажлын тоо хэмжээ

Д/д	Ажлын нэр	Тоноглолын үзүүлэлт, стандарт	Хэмжих нэгж	Тоо хэмжээ
1	Цахилгааны шитний ерөнхий оруулга кабель шугамыг тайлах	АВВГЗх120-1х70, ГОСТ 31996-2012	ш	23
2	Цахилгааны шитийг гагнуураар салгаж буулгах	ЕС-34	ш	21
3	Цахилгааны шитийг зоорийн давхраас зөөж гаргах	ЕС-34	ш	21
4	Шитний өрөөнд гэрэлтүүлэг хийх	ИЕК НПП-12 эсвэл түүнтэй дүйцэх	ш	21
5	Шит суурилуулах шалны хэсгийг тэгшилж бетондох	MNS 1185 : 1998	м3	21
6	Ерөнхий оруулга кабель шугамыг залгаас хийж уртасгах	АВВГЗх120-1х70, ГОСТ 31996-2012	м	69
7	Шитний хайрцгийг угсарч суурилуулах	1800х800х450 мм, зузаан 2,0 мм, IP31/54, ВРУ SMART ИЕК эсвэл түүнтэй дүйцэх, ГОСТ 32396-2013	ш	21

8	Сэлгэн залгагч угсрах	630 А, КЭАЗ ВР-32 эсвэл түүнтэй дүйцэх, ГОСТ 32396-2013	ш	23
9	Автомат сэлгэн залгагч угсрах	400А, DEKraft АВР-304-3Р-400А-I, эсвэл түүнтэй дүйцэх, ГОСТ Р 51732-2001	ш	2
10	Автомат таслуур угсрах	250А, ИЕК ВА 88-37 3Р эсвэл түүнтэй дүйцэх, ГОСТ Р 50030.2	ш	66
11	Автомат таслуур угсрах	160А, ИЕК ВА 88-35 3Р эсвэл түүнтэй дүйцэх, ГОСТ Р 50030.2	ш	7
12	Автомат таслуур угсрах	100А, ИЕК ВА 88-33 3Р эсвэл түүнтэй дүйцэх, ГОСТ Р 50030.2	ш	2
13	Автомат таслуур угсрах	63А, ИЕК ВА 88-33 3Р эсвэл түүнтэй дүйцэх, ГОСТ Р 50030.2	ш	4
14	Автомат таслуур угсрах	50А, ИЕК ВА 88-33 3Р эсвэл түүнтэй дүйцэх, ГОСТ Р 50030.2	ш	26
15	Автомат таслуур угсрах	25А, ИЕК ВА 88-32 3Р эсвэл түүнтэй дүйцэх, ГОСТ Р 50030.2	ш	26
16	Автомат таслуур угсрах	16А, ИЕК ВА 88-32 3Р эсвэл түүнтэй дүйцэх, ГОСТ Р 50030.2	ш	19
17	Гал хамгаалагч суурийн хамт угсрах	400А, ИЕК ППНИ-37, ДП-37 эсвэл түүнтэй дүйцэх, Габ-1, ГОСТ Р 50339.0-92	ком	25
18	Гал хамгаалагч суурийн хамт угсрах	250А, ИЕК ППНИ-37, ДП-37 эсвэл түүнтэй дүйцэх, Габ-1, ГОСТ Р 50339.0-92	ком	20
19	Зэс шин угсрах	40х4 мм, ШМТ эсвэл түүнтэй дүйцэх, ГОСТ 434-78	м	128
20	Зэс төгсгөвч шахах	50 мм кв, КВТ ТМЛ-50 эсвэл түүнтэй дүйцэх, ГОСТ 7386-80	ш	162
21	Хөнгөн цагаан төгсгөвч шахах	120 мм кв, КВТ ТА-120 эсвэл түүнтэй дүйцэх, ГОСТ 9581-80	ш	92
22	Шинийн тусгаарлах бүрээс угсрах	40 мм, ТИШ 10 эсвэл түүнтэй дүйцэх, ИЕС 60684-2	м	110
23	Хөндийрүүлэг изолятор угсрах	35 мм, М8, 380В, DEKraft ИО101-25 эсвэл түүнтэй дүйцэх	ш	460
24	Цэнэг шавхагч угсрах	ОПС1-В 3Р эсвэл түүнтэй дүйцэх, ИЕС 60099-5:2000	ш	23

25	Газардуулгын клем бэлтгэх	800 х 30 х 2,8 мм, 660В, Цахилгаан техникийн зэс	м	16.8
26	“0” клем бэлтгэх	800 х 50 х 5 мм, 660В, 12 нүхтэй, Цахилгаан техникийн зэс	м	16.8
27	Контрол кабель сувагт сунгах	ПУГВ1х1.5, ГОСТ 31947-2012	м	214
28	Амперметр угсрах	Аналог, 0-600А, Legrand 146 20 эсвэл түүнтэй дүйцэх	ш	24
29	Гүйдлийн трансформатор угсрах	600/5, EN60715	ш	72
30	Вольтметр угсрах	Аналог, 0-500В, Legrand 146 61 эсвэл түүнтэй дүйцэх	м	24
31	Гүйдэл, хүчдэлийн түлхүүр угсрах	10А, ИЕК ПКП10 эсвэл түүнтэй дүйцэх, IP20	ш	46
32	Хяналтын гэрэл	ИЕК, AL22 эсвэл түүнтэй дүйцэх	ш	25
33	Текстолит угсрах	1000х1000х6мм, ПТК эсвэл түүнтэй дүйцэх, ГОСТ 5-78	ш	2
34	Гаргалгаа кабель шугамыг залгаас хийж уртасгах	ПУГВ1х50, ГОСТ 31947-2012	м	552
35	Хөндийрүүлэгийн эсэргүүцлийг турших	MNSIEC 60225-1:2012	ком	23
36	Шиний холболтын эсэргүүцлийн туршилт	MNSIEC 60225-1:2012	ком	23

Тав. ЗАХИАЛАГЧИЙН ХЯНАЛТ

1. Цахилгааны шугам сүлжээг шинэчлэн солих ажлыг гүйцэтгэж эхлэх үеэс нь эхлэн ажлыг хийж дуусгах хүртлэх бүх технологийн үйл ажиллагаанд хяналт тавина.
2. Материалын чанарт хяналт тавих
3. Ажлын явцад гарах зураг, төсөвтэй холбоотой асуудлыг холбогдох хүмүүстэй хамтарч шийдвэрлүүлэх.
4. Магадлашгүй ажлын зардалд зориулсан мөнгөн дүнг төслийн менежерийн шийдвэрийн дагуу захиалагч, гүйцэтгэгч, ашиглагчийн төлөөлөгчид оролцсон комисс акт тогтоон, төсөв тооцоо хийж /шаардлагатай бол зураг хийх/ баталгаажуулж санхүүжүүлэх.

Зургаа. ГҮЙЦЭТГЭГЧ БАЙГУУЛЛАГА

1. Гүйцэтгэгч байгууллага нь ажлын тоо хэмжээ, зургийн дагуу ажлыг чанарын өндөр түвшинд, гэрээний хугацаанд багтаан гүйцэтгэнэ.
2. Захиалагч, ашиглагч байгууллагын төлөөлөгчдийг байлцуулан үе шатны ажил тус бүрийг фото зургаар баталгаажуулан, акт үйлдэнэ.
3. Гүйцэтгэгч нь хөдөлмөр хамгаалал, техникийн аюулгүй ажиллагааны нөхцлийг бүрэн хангаж, үүнээс гарах хор хохирлыг өөрсдөө хариуцна.
4. Мөн байгалийн гэнэтийн гамшиг, гал түймэр, үер усны гамшгаас сэргийлэн аюулгүй байдлыг бүрэн хангаж ажиллах ба хэрэв ямар нэг арга хэмжээ авалгүй гэнэтийн гамшигт өртвөл гүйцэтгэгч хариуцна.
5. Тендерт шалгарсан гүйцэтгэгч нь импортын материал ашиглах нөхцөлд гарал үүсэл, тохирлын гэрчилгээ, сертификат, лабораторийн шинжилгээний дүнг хавсаргасан байх.
6. Үндэсний үйлдвэрийн материалыг ашиглах нөхцөлд “Бүтээгдэхүүний тохирлын гэрчилгээ” лабораторийн шинжилгээний дүн хавсаргаж ирүүлнэ. Мөн орон нутгаас хэрэглэх элс, хайрганы шинжилгээний дүн, бетон зуурмагийн дээжээс сорилын шоо авч лабораторийн дүгнэлт гаргуулсан байна.
7. Чанаргүй хийсэн ажлыг өөрийн хөрөнгөөр захиалагчийн заасан хугацаанд засварлаж өгнө.
8. Шугам сүлжээг шинэчлэн солих ажлыг хийж гүйцэтгэх зохион байгуулалтын төлөвлөлтийг боловсруулж тендерт хавсаргаж ирүүлнэ.
9. Дээрх техникийн тодорхойлолтонд заагдсан шаардлагыг биелүүлээгүй нөхцөлд захиалагчийн төлөөлөгч, мэргэжлийн хяналтын улсын байцаагч нар эрхийнхээ дагуу ажлыг тодорхой хугацаагаар зогсоох хүртэл арга хэмжээ авах эрхтэй.

Долоо. ЖИШИГ МАЯГТ

ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

1. Бид, [тендерт оролцогчийн нэр], [гэрээний нэр ба дугаар]-ыг [тендерийн үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр тендерийн баримт бичгийн дагуу гүйцэтгэхээр санал болгож байна.
2. Тендер нь тендерийн баримт бичигт заасны дагуу тендер хүлээн авах эцсийн хугацаанаас хойш **30** хоногийн хугацаанд хүчинтэй байх ба та энэ хугацаа дуусахаас өмнө түүнийг сонгох боломжтой.
3. Гэрээг албан ёсоор байгуулах хүртэл энэхүү тендер болон түүнийг шалгарсан тохиолдолд гэрээ байгуулах эрх олгох мэдэгдэл нь бидний хооронд хийгдсэн хэлцэл болно.
4. Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.
5. Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгдөнө.

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

Найм. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|---|
| 1. Гүйцэтгэгч ажил гүйцэтгэх | 1.1. Гүйцэтгэгч гэрээний тусгай нөхцөлд заасан ажлыг техникийн тодорхойлолт болон зургийн дагуу хийж гүйцэтгэнэ. |
| 2. Төслийн менежерийн шийдвэр | 2.1. Гэрээнд тусгайлан заагаагүй бол гэрээтэй холбогдсон аливаа асуудлыг захиалагчийг төлөөлөн төслийн менежер шийдвэрлэнэ. |
| 3. Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр ажил дууссан байх | 3.1. Гүйцэтгэгч ажлыг гэрээний тусгай нөхцөлд заасан өдөр эхлүүлж, өөрийн гаргасан ажлын хөтөлбөр болон төслийн менежерийн баталсан тодотгосон ажлын хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэн, ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр дуусгана. |
| 4. Аюулгүй байдал | 4.1. Гүйцэтгэгч ажлын талбай дээрх бүх үйл ажиллагааны аюулгүй ажиллагааг хангаж ажиллана.
4.2. Барьж байгаа барилга, байгууламжаа байгалийн болзошгүй гамшиг, гэнэтийн аюулаас хамгаалах бүх талын арга хэмжээг авч, өөрийн нь ажилтай холбогдуулж барилгын болон байгаль орчин, эрүүл ахуй, гал түймрийн хяналтын албанаас гаргасан хууль ёсны шаардлага, дүгнэлтийг хүлээн авч биелүүлнэ. |
| 5. Зааварчилгаа | 5.1. Төслийн менежерийн гаргах аливаа зааварчилгаа нь Монгол улсын хууль, тогтоомжид нийцсэн байх бөгөөд түүнийг гүйцэтгэгч биелүүлэх үүрэгтэй |
| 6. Маргааныг шийдвэрлэх | 6.1. Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана. |

Б. ХУГАЦААНЫ БОЛОН ЧАНАРЫН ХЯНАЛТ

- | | |
|-------------------------------------|---|
| 7. Ажлын хөтөлбөр | 7.1. Гүйцэтгэгч нь ажил гүйцэтгэхэд шаардлагатай бүх үйл ажиллагааны ерөнхий аргачлал, зохион байгуулалт, дэс дараалал, ажил гүйцэтгэх хугацаа болон бусад шаардлагатай мэдээллийг тусгасан ажлын хөтөлбөрийг боловсруулж, гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд төслийн менежерт хүргүүлж батлуулна.
7.2. Ажлын хөтөлбөрийг төслийн менежер батлах нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Гүйцэтгэгч нь ажлын хөтөлбөрийг хянан засварлаад төслийн менежерт хэдийд ч дахин хүргүүлж болно. Хянан засварласан ажлын хөтөлбөрт өөрчлөлтийг тусгана. |
| 8. Зөрчил, гологдол илрүүлэх | 8.1. Төслийн менежер гүйцэтгэгчийн ажлыг шалгаж, илэрсэн зөрчил, гологдлын талаар түүнд мэдэгдэнэ. Энэхүү шалгалт нь гүйцэтгэгчийн үүрэг хариуцлагыг хөндөхгүй. Төслийн менежер зөрчил, гологдол байж болзошгүй гэж үзсэн аливаа ажилд зөрчил, гологдол хайх, уг ажлын далд хэсгийг нээж шалгалт, туршилт явуулах талаар зааварчилгааг гүйцэтгэгчид өгөх эрхтэй. |
| 9. Зөрчил, гологдол арилгах | 9.1. Төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан чанарын баталгаат хугацаа ¹ дуусахаас өмнө зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдлийг гүйцэтгэгчид өгнө. Чанарын баталгаат хугацааг зөрчил, гологдлыг арилгаж дуусах хүртэл сунгана.
9.2. Зөрчил, гологдол арилгах тухай мэдэгдэл өгсөн тухай бүр гүйцэтгэгч уг зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд |

¹ Чанарын баталгаат хугацааг тогтоохдоо Иргэний хууль болон Барилгын тухай хуулийг баримтална.

- заасан хугацаанд багтааж өөрийн зардлаар арилгана.
- 10. Зөрчил, гологдол арилгахгүй байх**
- 10.1. Хэрэв гүйцэтгэгч зөрчил, гологдлыг төслийн менежерийн мэдэгдэлд заасан хугацаанд багтааж арилгаагүй бол төслийн менежер зөрчил, гологдол арилгахад шаардагдах зардлыг тооцож гүйцэтгэгчээс гаргуулна.

В. ЗАРДЛЫН ХЯНАЛТ

- 11. Үе шатны ажлын хуваарь**
- 11.1. Төслийн менежерийн шаардсаны дагуу гүйцэтгэгч үе шатны ажлын тодотгосон хуваарийг 14 хоногийн дотор бэлтгэж ирүүлнэ. Үе шатны ажлын хуваарьт тусгагдсан үйл ажиллагаа нь ажлын хөтөлбөрт тусгагдсан үйл ажиллагаатай нийцсэн байна.
- 11.2. Ажлын талбай дахь материалын төлбөрийг тусад нь хийх бол гүйцэтгэгч ажлын талбайд нийлүүлсэн материалын тооцоог үе шатны ажлын хуваариас тусад нь гаргаж ирүүлнэ.
- 12. Үе шатны ажлын хуваарийг өөрчлөх**
- 12.1. Гүйцэтгэгчийн шийдвэрээр ажлын арга барил, эсхүл ажлын хөтөлбөрт гарсан өөрчлөлтийг тусгах зорилгоор гүйцэтгэгч үе шатны ажлын хуваарьт нэмэлт өөрчлөлт хийнэ. Өөрчлөлт хийхдээ үе шатны ажлын хуваарь дахь үнийг өөрчлөхгүй.
- 13. Алданги**
- 13.1. Гүйцэтгэгч нь ажил дуусгахаар төлөвлөсөн өдрөөс хугацаа хоцорсон хоног тутамд гэрээний тусгай нөхцөлд заасан хувь хэмжээгээр алданги² төлнө. Алдангийн нийт дүн гэрээний тусгай нөхцөлд заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй. Захиалагч нь алдангийг гүйцэтгэгчид төлөх төлбөрөөс суутган авч болно. Алданги төлсөн нь гүйцэтгэгчийн хүлээсэн үүрэг хариуцлагыг хөндөхгүй.

Г. ГЭРЭЭГ ДУУСГАХ

- 14. Ажил дуусгах**
- 14.1. Гүйцэтгэгч нь ажил дууссан тухай мэдэгдэл гаргах хүсэлтийг төслийн менежерт тавих бөгөөд төслийн менежер ажил дууссан гэж үзвэл уг мэдэгдлийг гаргана. Гүйцэтгэгч гадна тохижилтын ажлыг бүрэн дуусгаж, ажлын явцад гудамж, зам, талбай сэтэлж, мод, цэцэрлэгжүүлэлтийг түр зайлуулсан бол эдгээрийг бүрэн хэмжээгээр сэргээсэн байна.
- 15. Хүлээж авах**
- 15.1. Төслийн менежер ажил дууссан тухай мэдэгдэл гаргаснаас хойш захиалагч долоо хоногийн дотор ажлын талбай болон ажлыг хүлээж авна.
- 16. Эцсийн тооцоо**
- 16.1. Гүйцэтгэгч гэрээний дагуу төлөгдөх ёстой гэж үзэж буй нийт төлбөрийн нарийвчилсан тооцоог гаргаж, чанарын баталгаат хугацаа дуусахаас өмнө төслийн менежерт хүргүүлнэ. Төслийн менежер зөрчил, гологдол арилгасан тухай мэдэгдэл гаргаж, хэрэв гүйцэтгэгчийн ирүүлсэн тооцоо бүрэн гүйцэд, үнэн зөв бол уг тооцоог хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор гүйцэтгэгчид төлөх эцсийн төлбөрийг тодорхойлно. Хэрэв тооцоо буруу байвал шаардлагатай залруулга, нэмэлт өөрчлөлтийн талаарх тайлбарыг 14 хоногийн дотор гаргаж гүйцэтгэгчид хүргүүлнэ. Хэрэв засвар хийж дахин ирүүлсэн эцсийн тооцоо нь шаардлага хангаагүй бол төслийн менежер гүйцэтгэгчид төлөх дүнг шийдвэрлэж төлбөрийн мэдэгдэл гаргана.

² Алдангийг ихэвчлэн хоногт 0.05-0.10 хувиар тогтоох бөгөөд нийт дүн нь гэрээний үнийн 5-10%-иас хэтрэх ёсгүй.

- 17. Ашиглалт, засвар, үйлчилгээний гарын авлага**
- 17.1. Гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийн зураг, далдлагдсан ажил, инженерийн шугам сүлжээ, технологийн тоног төхөөрөмжийг туршиж тохируулсан акт болон захиалагч шаардсан бол ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд хүлээлгэн өгнө.
- 17.2. Хэрэв гүйцэтгэгч 22.1-д заасан материалыг гэрээний тусгай нөхцөлд заасан хугацаанд ирүүлээгүй, эсхүл шаардлага хангаагүйн улмаас тэдгээрийг төслийн менежер батлаагүй бол гүйцэтгэгчид төлөх ёстой төлбөрөөс төслийн менежер гэрээний тусгай нөхцөлд заасан үнийн дүнг суутгана.
- 18. Гэрээг цуцлах**
- 18.1. Захиалагч, эсхүл гүйцэтгэгч нөгөө тал нь гэрээг ноцтой зөрчсөн гэж үзвэл гэрээг цуцлах эрхтэй.
- 18.2. Дор дурдсан нөхцөлүүдийг гэрээний ноцтой зөрчил гэж үзэх бөгөөд эдгээрээр хязгаарлагдахгүй:
- (а) ажлын хөтөлбөрт ажил зогсоох тухай заагаагүй, түүнчлэн ажил зогсоох тухай шийдвэрийг төслийн менежер батлаагүй байхад гүйцэтгэгч ажлыг 28 буюу түүнээс дээш хоногийн хугацаагаар зогсоосон;
 - (б) төслийн менежер ажлын явцыг зогсоох зааварчилгааг гүйцэтгэгчид өгсөн бөгөөд уг шийдвэрээ 28 хоногийн дотор цуцлаагүй;
 - (в) захиалагч, эсхүл гүйцэтгэгч дампуурсан, эсхүл өөрчлөн байгуулагдах, нэгдэхээс бусад зорилгоор татан буугдсан;
 - (г) тодорхой зөрчил, гологдлыг арилгаж чадаагүй нь гэрээний ноцтой зөрчил болохыг төслийн менежер гүйцэтгэгчид мэдэгдсэн бөгөөд гүйцэтгэгч нь уг зөрчил, гологдлыг заасан хугацаанд нь багтаан арилгаж чадаагүй;
 - (д) гүйцэтгэгч ажлын гүйцэтгэлийг гэрээний тусгай нөхцөлд заасан алдангийн дээд хэмжээ төлөх хугацаагаар хоцроосон.
- 18.3. Гэрээг цуцалсан тохиолдолд гүйцэтгэгч ажлыг даруй зогсоож, ажлын талбайн бүрэн бүтэн, аюулгүй байдлыг хангаж, түүнийг аль болох түргэн хугацаанд чөлөөлнө.
- 19. Гэрээг цуцалсан үед хийх төлбөр**
- 19.1. Гүйцэтгэгч гэрээг ноцтой зөрчсөний улмаас гэрээ цуцлагдсан бол төслийн менежер гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээг нотолсон мэдэгдэл гаргана. Ингэхдээ мэдэгдэл олгосон өдөр хүртэл дуусаагүй ажлын гэрээний тусгай нөхцөлд заасан хэмжээг дээрх үнэлгээнээс хасна. Нэмэлт алданги гүйцэтгэгчид ногдуулахгүй.
- 19.2. Гэрээг захиалагчийн шаардлагаар, эсхүл гэрээг захиалагч ноцтой зөрчсөний улмаас цуцалсан бол гүйцэтгэсэн ажлын болон захиалсан материалын үнэлгээ, тоног төхөөрөмжийг ажлын талбайгаас гаргах бодит зардал, ажлын зорилгоор хөлслөн ажиллуулсан гүйцэтгэгчийн ажилтнуудыг буцаахтай холбогдсон зардал, түүнчлэн ажлыг хадгалах, хамгаалахтай холбогдсон зардал зэрэг гүйцэтгэгчийн зардлыг төслийн менежер хянаж мэдэгдэл гаргана.
- 20. Гүйцэтгэлээс чөлөөлөх**
- 20.1. Гэнэтийн болон давагдашгүй хүчний нөхцөл байдлын улмаас гэрээг гүйцэтгэх боломжгүй болсон бол төслийн менежер үүнийг

гэрчилнэ. Гүйцэтгэгч нь энэхүү мэдэгдлийг хүлээн авсны дараа ажлын талбайн бүрэн бүтэн байдлыг хангаж, ажлыг аль болох богино хугацаанд зогсооно. Захиалагч уг мэдэгдэл гарахаас өмнө хийгдсэн ажил болон түүний дараа захиалгаар гүйцэтгэсэн ажлын хөлсийг гүйцэтгэгчид төлнө.

Ес. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ³

ГЕН 2.1	Гэрээний нэр болон бүртгэлийн дугаар: ОСНААУГ-ГША-20/08
ГЕН 2.1	Ажлын талбай нь <i>Баянгол дүүргийн 20 дугаар хороонд</i> байрших ба ажлын зурагт зааснаар тодорхойлогдсон болно.
ГЕН 3.1	Төслийн менежер нь : <i>Захиалагч томилно.</i>
ГЕН 4.1	Ажил эхлэх өдөр: <i>Гэрээ хүчин төгөлдөр болсон өдрөөс</i> Ажил дуусгахаар төлөвлөсөн өдөр: <i>Гэрээ байгуулсан өдрөөс хуанлийн 30 хоногийн дотор</i>
ГЕН 7.1	Гүйцэтгэгч гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 5 хоногийн дотор тодотгосон ажлын хөтөлбөрийг гаргана.
ГЕН 9.1	Чанарын баталгаат хугацаа 3 жил байна.
ГЕН 13.1	Алданги ногдуулах хэмжээ хоногт гэрээний үнийн 0,5% байна. Нийт ажилд ногдуулах алдангийн дээд хэмжээ нь гэрээний үнийн 10% байна.
ГЕН 17.1	Гүйцэтгэлийн зургийг ажлыг хүлээлгэн өгснөөс хойш 14 өдрийн дотор гаргаж өгнө Гүйцэтгэлийн зургийг, эсхүл ашиглалт, засвар үйлчилгээний гарын авлагыг хугацаанд нь гаргаж өгөөгүй тохиолдолд суутгах төлбөрийн хэмжээ 200000 төгрөг байна.

³ Захиалагч тендерийн баримт бичгийг тараахаас өмнө гэрээний тусгай нөхцөлийг бүрэн бөглөсөн байна. Захиалагчийн гаргах хуваарь, тайланг гэрээний тусгай нөхцөлд хавсаргана.

ГЭРЭЭНИЙ МАЯГТ

ЗАХИАЛАГЧ

ГҮЙЦЭТГЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

..... хот/аймаг

Нэг талаас [захиалагчийн нэр] (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас [гүйцэтгэгчийн хот, улс, гүйцэтгэгчийн нэр] (цаашид “гүйцэтгэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны ____ сарын _____-ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний хууль, Барилгын тухай хууль болон бусад хууль тогтоомжийн дагуу инженерийн хийцтэй барилга байгууламж барих, засварын ажил гүйцэтгэх, тоног төхөөрөмж суурилуулахтай холбогдон захиалагч, гүйцэтгэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.

2. Захиалагч нь [гэрээний нэр, дугаар]-г (цаашид “ажил” гэх) [гэрээний үнийг тоогоор болон үсгээр] (цаашид “гэрээний үнэ” гэх) гүйцэтгэхээр ирүүлсэн гүйцэтгэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ буюу ажлын нийт төсөвт өртөг нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.

3. Гэрээний нийт дүн: _____ төгрөг. Үүнээс: /Аль тохирохыг нь бөглөнө, бусдыг нь устгана/

Улсын төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Орон нутгийн төсвөөс: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг;

Өөрийн хөрөнгө: 20.... онд: _____ төгрөг; 20.... онд: _____ төгрөг.

4. Гүйцэтгэгч нь _____ байршилтай _____ хүчин чадал бүхий _____ ам.метр талбай / _____ шоо метр эзлэхүүн/-тай, _____ суурь, _____ хана, _____ хучилттай, _____ давхар _____ барилга угсралт /барилгын засвар, тоног төхөөрөмж суурилуулах/-ын ажлыг _____ инженерийн шугам сүлжээ /дулаан, цахилгаан, цэвэр, бохир усан хангамж/, _____ туслах барилга /бусад ажил/-ын хамт _____ оны ____ дугаар сарын _____-ны өдөр эхэлж, _____ оны ____ дугаар сарын _____-ны өдөр ашиглалтад оруулна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

- 5.1. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
- 5.2. Бусад шаардлагатай баримт бичиг ;
- 5.3. Үнийн санал
- 5.4. Гэрээний тусгай нөхцөл;

- 5.5. Гэрээний ерөнхий нөхцөл;
- 5.6. Техникийн тодорхойлолт;
- 5.7. Зураг;
- 5.8. Гүйцэтгэгчийн ирүүлсэн үе шатны ажлын хуваарь ;
- 5.9. Санхүүжилтийн хуваарь;
- 5.10. Ажил гүйцэтгэх хуваарь.

Гэрээ нь энд дурдсан ажлыг гүйцэтгэх талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний бичиг баримтууд хоорондоо зөрчилдвөл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Захиалагч, гүйцэтгэгч нь гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлд заасан эрх, үүрэг хүлээнэ.

7. Гүйцэтгэгч нь гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан ажлыг гүйцэтгэж, зөрчил, гологдол арилгах үүрэг хүлээнэ.

8. Захиалагч нь гэрээний дагуу гүйцэтгэгчийн хийх ажил болон зөрчил, гологдол арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний төлбөрийг гүйцэтгэгчид төлөх үүрэг, хүлээнэ.

9. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр болон утсан холбоогоор харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

ГҮЙЦЭТГЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

[Албан тушаал, нэр]
*[Гарын үсэг]*_____

ТАМГА

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]